



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/24

Бодь

Г Эрүүл мэндийн төвийн орчин нөхцөл
сайжруулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.5, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.10, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1, аймгийн Онцгой комиссын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлийн 9.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн стационарын барилга нь 2006 онд ашиглалтанд орсноос хойш урсгал засвар хийгдээгүй, 2020 онд амбулаторын шинэ барилга баригдсан боловч гадна талын хайс, тохижилт, түргэн тусламжийн автомашины дулаан граш, мооргын барилга зэрэг нь стандартын шаардлага хангахгүй, өвчтөн хүлээн авах хэвтүүлэн эмчлэх нөхцөл тааруу, үйлчлүүлэгчийн ая тухтай орчинг сайжруулахыг Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэнхүү)-д үүрэг болгосугай.

2. Эрүүл мэндийн төвийн гадна талын хайс, тохижилт, түргэн тусламжийн автомашины дулаан граш, стандартын шаардлага хангасан мооргын барилга зэргийг барих 58.000,000 (тавин найман сая) төгрөгийг Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтын данснаас зарцуулахыг Нягтлан бодогч (Ц.Төмөрбат)-д зөвшөөрсүгэй.

3. Эрүүл мэндийн төвийн тохижилт үйлчилгээ шинээр барих, барилга байгууламжийг чанартай хийж гүйцэтгэхийг Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэнхүү)-д үүрэг даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д үүрэг даалгасугай.

ДАРГА



Р.БАТЖАРГАЛ